



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/152

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 65 дугаар зүйлийн 65.1.4, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 24 дүгээр зүйлийн 24.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит IX хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрдэнэбулган сумын зэрлэг багийн төвийг суурин газартай холбодог гол зам болох Төмстийн дээд, доод хясаа Эгийн голын халиа, шар усны үерийн улмаас эвдрэлд орж тээврийн хэрэгсэл зорчих боломжгүй болсон тул зам засвар арчлалтын зардалд шаардлагатай 78,955,737 (Далан найман сая есөн зуун тавин таван мянга долоон зуун гучин долоо) төгрөгийг Замын сангийн нөөц хөрөнгөнөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа), аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар) нарт тус тус зөвшөөрсүгэй.

2. Дээрх сумын авто замын засвар арчлалт хийх ажлыг Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Эрдэнэбулган сумын Засаг дарга (Б.Эрдэнэнаранд)-д, арга зүй удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН